



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



**Товчилсон нэр томъёоны тайлбар**

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДГ	Дорноговь
ДО	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ОР	Орхон
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
АД	Аймгийн дүн
УБ	Улаанбаатар
УД	Улсын дүн
ҮСГ	Үндэсний статистикийн газар
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ДОХ	Дархлалын олдмол хамшинж
ДОТС	Богино хугацааны шууд хяналттай эмчилгээ
СТДХ	Сүрьеэтэй тэмцэх дэд хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
ХӨЦМ	Хүүхдийн өвчний цогц менежмент



## Гарчиг

### Бүлэг I. Монгол Улсын хүн ам

- 1.1 Хүн ам
- 1.2 Хүн амын насны суварга
- 1.3 Монгол улсын хүн ам ба хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

### Бүлэг II. Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд

### Бүлэг III. Эх хүүхдийн эрүүл мэнд

- 3.1 Эхийн эрүүл мэнд
  - 3.1.1 Жирэмсний үеийн болон төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ
  - 3.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ
  - 3.1.3 Төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ
  - 3.1.4 Эхийн эндэгдэл
  - 3.1.5 Үр хөндөлт
  - 3.1.6 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглээ
- 3.2 Хүүхэд өсвөр үеийнхний эрүүл мэнд

### Бүлэг IV. Эмнэлгийн тусламж үйлчилгээ

- 4.1 Эмнэлгийн анхдагч шатлалын тусламж үйлчилгээ
  - 4.1.1 Өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээ
  - 4.1.2 Сумын болон сумдын эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 4.2 Эмнэлгийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээ
- 4.3 Эмнэлгийн гуравдагч шатлалын тусламж үйлчилгээ
- 4.4 Эмийн улсын бүртгэлийн тухай

### Бүлэг V. Халдварт өвчин

- 5.1 Гэдэсний халдвар
- 5.2 Амьсгалын замын халдвар
- 5.3 Бэлгийн замаар дамжих халдвар

### Бүлэг VI. Халдварт бус өвчлөл

- 6.1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан
- 6.2 Стационарт бүртгэгдсэн өвчлөл
- 6.3 Хүн амын нас баралт

### Бүлэг VII. Эрүүл мэндийн эдийн засаг

- 7.1 Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн зарим үзүүлэлтүүд
- 7.2 Эмийн зардал эмнэлгийн тусламж үйлчилгээ шатлалаар
- 7.3 Хөрөнгө оруулалт
- 7.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт  
Хавсралт

### Бүлэг VIII. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүд

### Бүлэг IX. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд, 2005 он









хөтөлбөрийн хүрээнд оношилгоо эмчилгээний олон улсын стандарт (ДОТС)-ыг нэвтрүүлж, амжилтай хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд ДОТС-ын хамралт 2000 оноос хойш 100 хувь, эмчилгээний үр дүн 80-иас дээш хувьтай байна.

**Хүснэгт 2.3 Сүрьеэ өвчний тархалт, нас баралтын түвшин (100 000 хүн амд), сонгосон онуудаар**

Он	1990	2000	2003	2004	2005	2015
<b>Сүрьеэгийн тархалтын түвшин</b>						
Улсын дундаж	79	125	155	176	175	40
УБ хот	85	180	234	264	264	-
Аймгийн дундаж	63	99	115	129	123	-
<b>Сүрьеэгийн нас баралтын түвшин</b>						
Улсын дундаж	4.8	3.2	3.0	3.8	4.0	-
УБ хот	5.4	2.5	2.6	3.3	3.3	-
Аймгийн дундаж	3.9	2.0	3	4.5	4.3	
<b>ДОТС-ын хүрээнд илрүүлж эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь</b>						
Улсын дундаж	-	100/80	100/83.8	100/83	100/79	
УБ хот	-	100/84	100/82	100/84	100/74	
Аймгийн дундаж	-	100/81	100/85	100/87	100/84	


## БҮЛЭГ III. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### 3.1 Эхийн эрүүл мэнд

2005 онд :

- “Эхийн эндэгдлийг бууруулах 2005-2010 оны стратеги”-ийг боловсруулж ЭМСайдын 2005 оны 35 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.
- 2004-2008 онд хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхаарч, мянганы хөгжлийн зорилтод нийцүүлэн эх хүүхдийн /нярайн/ эндэгдлийг бууруулна гэж заасан байна.
- “Эх, хүүхдэд ээлтэй аймгийн Засаг дарга шалгаруулах тухай”, “Эхийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний тухай”, “Эхчүүдийн амрах байрны бүтэц, санхүүжилтийн журам батлах тухай” ЭМ-ийн Сайдын тушаал, заавар, журам батлан хэрэгжүүлж байна.
- НҮЭМ, Үндэсний бусад хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийн хамгийн гол шалгуур болох эхийн эндэгдлийн түвшин 100 000 амьд төрөлтөд 2004 онд анх удаа 2 оронтой тоонд шилжин буурсанаар энэ үзүүлэлт 2005 онд 93.0 болсон байна.

**Зураг 3.1 Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд /1995-2005/**



#### 3.1.1. Жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

Жирэмсэн эмэгтэйд үзүүлэх төрөхийн өмнөх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дараах үйл ажиллагаануудыг хамруулан ойлгодог. Үүнд:

- Жирэмснийг эрт илрүүлж, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа эмчийн хяналтад авах
  - Жирэмсэн эхчүүдийг цусны ерөнхий шинжилгээ, БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулах
  - Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, тэдгээрийг эрт илрүүлэх, цаг алдалгүй эмчлэх
  - Жирэмсэн эхчүүдийг амин дэм болон бичил элементээр хангах
  - Эхчүүдийн амрах байрны үйлчилгээг сайжруулах

Жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсний эрт үеийн болон байнгын хяналтад орох нь хавсарсан өвчлөлийг оношлох, эмчлэх улмаар жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Мөн жирэмсэн эмэгтэйг төрөхөөс өмнө эмчийн зөвлөсөн хугацаанд, төрсөн эхийг төрсний дараа амаржих газраас гарснаас хойш 7 хүртлэх хоногоор амрах үйл ажиллагааг жигдрүүлэхэд эхийн амрах байрны гол зорилго оршино.

2005 оны байдлаар нийт жирэмсэн эхчүүдийн 80.0 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтад хамрагдсан байна. Хот, хөдөөгөөр авч үзэхэд хотод төрсөн эхчүүдийн 74.9 хувь нь, хөдөө төрсөн эхчүүдийн 83,0 хувь нь жирэмсний эрт үеийн хяналтад хамрагдсан байна.





### 3.1.3 Төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ

Төрсний дараах үед нь төрсөн эхчүүдэд хүүхдээ асрах, хөхөөр хооллох, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр зөвлөгөө өгдөг.

НҮЭМ- 2003 судалгааны үр дүнд сүүлийн 5 жилд хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 62 хувь нь хамгийн сүүлчийн хүүхдээ төрүүлснээс хойш 42 хоногийн дотор эмчээс зөвлөгөө авсан. Эдгээр эмэгтэйчүүдийн 60 хувь нь хөхөөр хооллолт, 59 хувь нь нярайн асаргаа, 37 хувь нь гэр бүл төлөвлөлт, 32 хувь нь БЗДХ гэсэн чиглэлээр зөвлөгөө авчээ. 2005 оны эрүүл мэндийн статистикийн бүртгэлээр төрсний дараа 42 хоногийн дотор идэвхитэй хяналтад хамрагдагсдын хувь 74.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны хяналтын хувьтай харьцуулахад 7.1 пунктээр нэмэгдсэн байна.

2005 онд 1 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 99.2, 5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 92,9 байна.

#### Хүснэгт 3.2 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2005 он

Бүсээр	Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2005 он					
	Төрсөн хүүхэд				Нийт төрөлтөд	
	Бүгд	Эрэгтэй	эмэгтэй	Хүйсийн харьцаа /1000-д/	2500 граммаас доош жинтэй хүүхдийн эзлэх хувь	Амьгүй төрөлт /1000 төрөлтөнд/
Баруун бүс	8418	4357	4061	107.3	0.62	3.32
Төвийн бүс	6236	3235	3001	107.8	0.40	0.70
Хангай, говийн бүс	9458	4779	4679	102.1	0.70	2.32
Зүүнбүс	3318	1727	1591	108.5	0.27	0.66
<b>Аймгийн дүн</b>	<b>27430</b>	<b>14098</b>	<b>13332</b>	<b>105.7</b>	<b>2.01</b>	<b>7.02</b>
Улаанбаатар	17741	9171	8570	107.0	1.88	2.70
<b>Улсын дүн</b>	<b>45171</b>	<b>23269</b>	<b>21902</b>	<b>106.2</b>	<b>3.89</b>	<b>9.72</b>

Нийт төрсөн эхчүүдийн 6.0 хувь нь 20-иос доош насны, 84.5 хувь нь 20-34 настай, 9.5 хувь нь 35-аас дээш настай байна. НҮЭМ-ийн 1998 оны судалгаагаар 15-19 насны охидын 9 хувь нь хүүхэд төрүүлж байсан бол эрүүл мэндийн статистикаар 2005 онд 6.0 хувь болж буурчээ. 1998 онд хүүхэд төрүүлсэн өсвөр насны охидын хувь хотод 5.7, хөдөөд 12.9 байснаа 2005 онд хотод 5.4, хөдөөд 6.5 болсон нь нөхөн үржихүйн талаар хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн үр дүн хот хөдөөд хүртээмжтэй байгаагийн илрэл гэж үзэж болох юм.

Нийт төрсөн эмэгтэйчүүдийн 27.4 хувь нь жирэмсэн байх үедээ ямар нэгэн хавсарсан өвчнөөр өвдсөн байна. Үүнээс 44.5 хувь нь шээс бэлгэсийн тогтолцооны өвчин, 12.1 хувь нь цусны эргэлтийн тогтолцооны өвчтэй байна.

2004 онд жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн хүндрэлийн түвшин 1000 амьд төрөлтөд 490 байсан бол 2005 онд 762 болж нэмэгдэж нийт 34384 хүндрэлийн тохиолдол бүртгэгдээд байна. Үүнээс 28.0 хувийг жирэмсэн үеийн, 37.9 хувийг төрөх үеийн хүндрэл, 1.6 хувийг төрсний дараах үеийн хүндрэл, 32.5 хувийг жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчин тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд амьд төрсөн 45171 хүүхдийн 3.89 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ. Энэ үзүүлэлт нь Улаанбаатар хот, хангай говийн бүс нутгуудад өндөр байна. Амьгүй төрөлт 1000 төрөлтөнд 9.7 байгаа ба нийт 439 тохиолдлоос баруун болон хангай, говийн бүсэд бусад бүсийн үзүүлэлтээс өндөр байна. Амьгүй төрөлтөнд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь ихэнхи бүс нутагт өндөр байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 106.2 байна. Амьд төрсөн хүүхдээс 772 хоёр ихэр, 12 гурав ихэр байна.


### 3.1.4. Эхийн эндэгдэл

Монгол улсад 2000-2004 онд эхийн эндэгдэл буурч 100000 амьд төрөлтөнд 158.5 байсан эхийн эндэгдэл 2005 онд 93.0 болж 65.5 пунктээр буурч эхийн эндэгдлийг бууруулах 2001-2004 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүллээ. “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” (2005-2010) боловсруулж хэрэгжүүлж эхлээд байна.

2005 онд 42 эх эндсэнээс Булган, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Төв зэрэг аймагт эхийн эндэгдэл гараагүй байна. Эндсэн эхчүүдийн 9.5 хувийг 35-аас дээш насны, 11.9 хувийг 20-оос доош насны, 78.6 хувийг 20-34 насны эмэгтэйчүүд эзэлж байна. Ялангуяа 20-оос доош насны эх эндэж байгаа нь анхаарал татсан асуудлын нэг болж байна. Байршлаар авч үзэхэд нийт эндсэн эхчүүдийн 2/3-аас илүү хувь нь хөдөөд байна. Эхийн эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл жирэмсэн үеийн хүндрэлээр 23.8, төрөх үеийн хүндрэлээр 16.6, төрсний дараах үеийн хүндрэлээр 26.2, жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчнөөр 33.3 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх оны байдалтай харьцуулахад эндэгдлийн шалтгаанд төрөх үеийн хүндрэлийн хувь багасч харин төрсний дараах үеийн хүндрэлийн эндэгдэл нэмэгдсэн байхад ихэнхи аймгуудад төрсний дараа 42 хоногийн дотор идэвхитэй үзлэгт хамрагдагсдын хувь улс, аймгийн дундажаас доогуур байна.

**Зураг 3.4 Эхийн эндэгдэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалаар**



Эндсэн эхчүүдийн 28.6 хувь нь малчин, 54.7 хувь нь гэрийн ажилтай эхчүүд байгаа нь “2000-2004 оны эхийн эндэгдлийн итгэмжит лавлагаа” судалгаатай харьцуулбал эндсэн эхийн ажил эрхлэлтийн байдлаас үзэхэд малчин 45.2, гэрийн ажилтай 30.8 хувьтай байгаа нь эрүүл мэндийн статистиктай ойролцоо үзүүлэлттэй байна.

### 3.1.5 Үр хөндөлт

Монгол улсад хүн амын НҮЭМ-ийн нэг тулгамдаж байгаа асуудал бол үр хөндөлтийн түвшин буурахгүй байхын зэрэгцээ үр хөндөлтийн тоо бодитойгоор мэдээлэгдэхгүй байгаа явдал юм. 2005 онд үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээний стандартыг мөрдөж эхэлсэн ба үр хөндөлтийн тусламж үйлчилгээнд орчин үеийн аргуудыг нэвтрүүлж эхлээд байна. НҮЭМ-2003 судалгааны үр дүнгээр судалгааны өмнөх 5 жилийн хугацаанд үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 214, нөхөн үржихүйн насны 1 эмэгтэйд 0.7 байлаа. Эрүүл мэндийн 2005 оны статистикаар 1000 амьд төрөлтөд 200, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 12 үр хөндөлт тус тус ногдож байна. 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн түвшин Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Хэнтий, Улаанбаатар хотод улсын дундажаас өндөр байна. Эрт үеийн үр хөндөлтийн хувь 95.0 байна.

Насны бүлгээр авч үзэхэд нийт үр хөндөлтийн 6.9 хувийг 20-иос доош насны, 67.1 хувийг 30-34 насны, 26.0 хувийг 35 дээш насны эмэгтэйчүүд тус тус эзэлж байна. Үр хөндүүлж байгаа эмэгтэйчүүдийн 53.6 хувь нь анхны удаа үр хөндүүлж байгаа хүмүүс эзэлж байна.

### 3.1.6 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглээ /ЖСА/

Монгол улсын хүн амын дунд жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн талаарх мэдлэг, хэрэглээ өсч байгаа нь эмэгтэйчүүд болон хосуудад төрүүлэх хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацааг зохицуулах боломжуудыг нэмэгдүүлж, хууль бус үр хөндөлтийг бууруулах нэг арга зам болж байна. ( )











**Хүснэгт 4.2.1 Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар болон хүртээмж, үзүүлэлтүүд, сонгосон онууд**


Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2003	2004	2005	
Эмнэлгийн орны тоо	4018	3933	3811	3920
Дундаж ор хоног	10.1	9.6	9.3	9.6
Хоног болоогүй нас баралтын хувь	28.0	25.9	34.6	29.6
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	108234	112963	114207	111801
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо		1614236	1562485	1588360.5
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	78.9	77.3	139.0	98.4
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	20.0	17.4	16.3	17.9
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	81.8	-	82.3	82.0
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	27.1	28.1	27.2	27.5

Сүүлийн 3 жилд дунджаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 27 хувийг хөдөөнөөс буюу сум, сум дундын эмнэлгээс илгээсэн өвчтнүүд эзэлж байна. Энэ нь 2003-2005 онд хөдөөнөөс аймгийн нэгдсэн эмнэлэгт ирж хэвтэн эмчлүүлэгчдийн эзлэх хувь нэг түвшинд байгааг харуулж байна.


Аймгийн нэгдсэн эмнэлгийн нялхсын эндэгдлийн түвшин 2003 онд 20.0 байсан бол энэ үзүүлэлт сүүлийн 2 жилд тогтвортой буурч, 2005 онд 16.3 болж сүүлийн 3 жилийн дундаж 17.9 байна.

Улсын хэмжээнд эхийн эндэгдлийн түвшин сүүлийн 3 жилд тогтвортой буурч байгаа хэдий ч аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 100 000 амьд төрөлтөнд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2003 онд 78.9 байсан бол 2005 онд 139 болж нэмэгдсэн байна. Нөгөөтэйгүүр 2003 онд улсын хэмжээнд эндсэн эхийн 20 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт эндэж байсан бол 2005 онд 40 хувь болж нэмэгдсэн байна.

**Эхийн эндэгдэл, байршлаар 2003 он**



**Эхийн эндэгдэл, байршлаар 2005 он**










Фармакологийн ангиллаар ангилахад микроб, вирус, паразитын эсрэг нөлөөлөх бэлдмэлүүд 199 (14%), төв мэдрэлийн системд нөлөөлөх эм 121 (9%), зүрх судасны системд нөлөөлөх эм 121 (9%), хоол боловсруулах үйл ажиллагаанд нөлөөлөх эм 88 (6%) амьсгалын эрхтнүүдийн үйл ажиллагаанд нөлөөлөх эм бэлдмэл 47 (3%), бусад эм бэлдмэл 800 (59%) байна (Зураг 3)

Зураг 4.4.3. Эмийн бүртгэгдсэн байдал (Фармакологийн ангиллаар)




- Микроб, вирус, паразитын эсрэг нөлөөлөх эм
- Төв мэдрэлийн системд нөлөөлөх эм
- Зүрх судасны систем нөлөөлөх эм
- Хоол боловсруулах үйл ажиллагаанд нөлөөлөх эм
- Амьсгалын эрхтнүүдийн үйл ажиллагаанд нөлөөлөх эм
- Бусад



Вирус гепатит В-ийн өвчлөл 0-14 насанд 68(7.61), 15-19 насанд 283(32.6), 20-24 насанд 276(31.8), 25-29 насанд 126(14.7%), 30-аас дээш насанд 108(12.5%) тохиолдол тус тус байна. Өвчлөл 15-29 насанд зонхилон буюу 79.1%-ийг эзэлж байна.

Вирус гепатит С-ийн өвчлөл 0-4 насанд бүртгэгдээгүй. 5-9 насанд 3(1.8), 10-14 насанд 5(3), 15-19 насанд 17 (10.3), 20-24 насанд 24(13.9), 25-29 насанд 33(20), 30-34 насанд 27(16.3), 35-39 насанд 20(12.1), 40-44 насанд 10(6.06), 45-49 насанд 13(7.8), 50-54 насанд 9(5.8), 55-59 насанд 2(1.2), 60-аас дээш насанд 3(1.8) тохиолдол тус тус байна.

**Зураг 5.1 Вирус гепатитийн өвчлөл, нас баралт, хандлага, 1992-2005 он**



### Цусан суулга

Бүртгэгдсэн нийт халдварт өвчний 5.7 хувь, гэдэсний халдварт өвчний 24.4 хувийг тус тус эзэлж, өвчлөл өнгөрсөн оноос 380 тохиолдлоор буюу 1.6 %-р буурсан байна. Бүртгэгдсэн нийт халдварын 73,2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн ба Дорноговь (10,0), Хэнтий (8.4%) аймаг, Улаанбаатар хотод (14,6%) өвчлөл улсын дундаж (7.3)-аас өндөр, Баян-Өлгий, Баянхонгор аймгуудад өвчлөл бүртгэгдээгүй, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгуудад өвчлөл өнгөрсөн оноос 0.3-1.3% –р нэмэгдсэн байна.

2005 онд 8 аймагт өвчлөл ихэссэн ба Дорноговь, Өмнөговь, Хэнтий аймгууд, Улаанбаатар хотод өвчлөл сүүлийн 5 жилийн дундажаас 0.7-9.4 % – оор өндөр байна. 2005 онд бүртгэгдсэн цусан суулга өвчнийг насны ангилалаар авч үзэхэд: 0-4 насны өвчлөл нийт өвчлөлийн 53.4% эзэлж байна.

ХӨСҮТ-ийн лабораторид хийсэн цусан суулгын оноошийн шинжилгээнд 2645 хүнд нян судлалын шинжилгээ хийхэд 564/21.3%, голомтын 1380 сорьцонд 39/2.8%-д эерэг гарчээ.

### Балнад

Нийт халдварын 0.04%-ийг эзэлж, Булган /4/, Дархан-Уул /5/, Орхон /3/, Дорнод /1/ , Улаанбаатар хотод /1/ нийт 14 тохиолдол бүртгэгдсэнээс нас баралтын тохиолдол гараагүй байна. 2005 онд Дархан –Уул аймгийн Хонгор суманд (5), Булган аймгийн Хишиг – Өндөр суманд (4) тохиолдол тус тус бүртгэгдэв. Мөн Орхон аймагт 3 тохиолдол бүртгэгдсэн нь ах, дүүс байлаа. 2005 онд Дархан –Уул аймгийн Хонгор суманд гэдэсний халдварын тахал тархалт бүртгэгдэн 38 хүн өвчилснөөс балнадаар 4, цусан суулга 22, сальмонеллёзийн халдвараар 12 хүн өвчилсэн байна.






### 5.3 Бэлгийн замаар дамжих халдвар

Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т гурван өвчний 15315 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 47.4%-ийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 1640 тохиолдлоор нэмэгдсэн байна. БЗДХ-ын дотор трихомониаз 42.8%, заг хүйтэн 41.6%, тэмбүү 15.6%-ийг тус тус эзэлж байна. 10000 хүн амд оногдох өвчлөлийг авч үзвэл; трихомониаз /26/, заг хүйтэн /25.3/, тэмбүү /9.5/ тус тус өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдсэн байна. Бүртгэгдсэн тэмбүүгийн 78.7% нь хот суурин газарт, 21.3% нь сум, багт оршин суугчид, заг хүйтний 79.3% нь хот сууринд, 20.6% нь сум, багт оршин суугчид байна. 2005 онд төрөлхийн тэмбүүгийн 36 тохиолдол бүртгэгдсэний 24 (66.6%) нь хот суурин газар, 12 (33.4%) нь сум, багт илэрсэн байна.

Улаанбаатар хотод ХДХВ-ын халдвартай 10 тохиолдол, ДОХ-той 1 тохиолдол тус тус бүртгэгдэв. Бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын тохиолдлыг насаар авч үзвэл; ХДХВ-ын халдвартай хүн 25-29 насанд 3, 35-39 насанд 3, 40-44 насанд 4, ДОХ-той хүн 30-34 настай байна. Мөн албан ёсны бүртгэл мэдээнд одоогоор тусгагдаагүй байгаа дараахи БЗДХ-т өвчний тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд: бэлгийн замын герпесийн 69 тохиолдол, бэлгийн замын кандидийн 1459 тохиолдол, бусад 744 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 5.3 Зонхилон тохиолдох БЗДХ өвчлөлийн хандлага 1991-2005 он



2005 онд жирэмсэн эмэгтэйчүүдэд хийсэн үзлэгийн дүнгээс үзвэл тэмбүүтэй 2.3%, заг хүйтэнтэй 1.5%, трихомониазтай 3.1% буюу нийтдээ 7.1% нь БЗДХ-тай илэрчээ.





**Хүснэгт 6.2.1 Стационарт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшин 10000 хүн амд, 2005 он**

Өвчний ангилал (ӨОУА-10)	Сумын хүн амын өвчлөл	Аймгийн хүн амын өвчлөл	УБ хотын хүн амын өвчлөл	Ниит хүн амын өвчлөл
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	373.68	397.14	314.09	366.27
Амьсгалын тогтолцооны өвчин	325.24	341.77	297.01	325.14
Хоол шингээх эрхтний өвчин	194.26	291.64	389.41	327.98
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	247.29	280.94	328.89	298.76
Мэдрэлийн тогтолцооны өвчин	62.99	118.58	156.89	132.82
Бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	39.19	69.49	153.52	100.72
Халдварт ба шимэгч зарим өвчин	23.08	75.6	118.24	91.45
Яс булчин холбох нэхдэсийн өвчин	49.92	67.71	99.51	79.53
Арьс ба халимны өвчин	49.03	70.47	65.16	68.5
Сэтгэцийн ба аягийн эмгэг	12.85	38.07	78.94	53.26
Хавдар	10.21	19.8	79.48	41.98
Нүд ба түүний дайврын өвчнүүд	2.77	13.92	53.49	28.63
Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчинүүд	12.15	16.32	26.77	20.45
Чих ба хөхөнцрийн өвчин	12.78	18.21	12.58	16.12
Бусад	61.13	275.36	370.24	310.35
<b>Бүгд</b>	<b>1476.57</b>	<b>2095.02</b>	<b>2544.22</b>	<b>2261.96</b>

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтцийг байршлын хувьд авч үзэхэд ялгаатай байдал ажиглагдаж байна. Жишээ нь: Сумын болон аймгийн хүн амын эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд шээс бэлгэсийн тогтолцооны болон амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл орж байхад Улаанбаатар хотын эмнэлэгүүдэд хэвтэж эмчлүүлэгчдийн тэргүүлэх шалтгаанд хоол шингээх эрхтний болон цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлүүд тэргүүлж байна.

2005 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан дотор зонхилж буй өвчнүүдийг авч үзвэл: Шээс бэлгэсийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 56.7 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчний дотор уушигны хатгалгааны улмаас хэвтэн эмчлүүлэгчид 39.8 хувийг, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 25.6 хувийг, цусны эргэлтийн тогтолцооны өвчний дотор даралт ихсэх өвчин 31.3 хувийг тус тус эзэлж байгаа нь эдгээр өвчнүүд хүн амын дунд зонхилон тохиолддогийг харуулж байна.

Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин нь 2000 онд шээс бэлгэсийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 56.7 хувийг эзэлж байсан бол 2003 онд 63.1 хувь, 2005 онд 69 хувь болж, 2000 онтой харьцуулахад 13 хувиар нэмэгдсэн байна.








2005 оны байдлаар хорт хавдартай хэмээн оношлогдсон хүн амын 82.6 хувь нь өвчнийхөө III, IV Үе шатанд оношлогдож, нас барсан нийт хүн амын 79.7 хувь нь анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртлэх хугацаанд амьдарсан байна.

Осол гэмтэл хордлого, гадны шалтгаант өвчний улмаас нас барах тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж 1990 онд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааны дотор 5 дугаарт, 1994 онд 4 дүгээрт орж байсан бол 2000 оноос хойш тогтмол 3 дах шалтгаан болж байна. 10000 хүн амд ногдох осол гэмтлийн шалтгаант нас баралт 1995 онд 6.0, 2000 онд 7.6, 2005 онд 11.1 болж, 2000 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна.

**Зураг 6.3.5 Осол гэмтлийн шалтгаант нас баралтын хэлбэр, 10000 хүн амд**



Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг хэлбэрээр авч үзвэл 19.0 хувь нь зам тээврийн осол, 16.5 хувь нь амиа хорлох, 49.5 хувь нь бусдад хорлогдсон, 15.0 хувь нь бусад ослоор нас барсан байна. Нөгөөтэйгүүр эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн 10 000 хүн амд ногдох амиа хорлосон тохиолдлын тоо 6 дахин, бусдад хорлогдсон тохиолдлын тоо 5 дахин, зам тээврийн ослын тохиолдлын тоо 7 дахин дахин их байна.


## БҮЛЭГ VII. Эрүүл мэндийн эдийн засаг

### 7.1 Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд:

Эрүүл мэндийн салбарын зардлыг 2000-2004<sup>1</sup> оны байдлаар гаргалаа. Эрүүл мэндийн салбарын зардал жил бүр өссөн байна. Тухайлбал 2000 оныг суурь болгон эрүүл мэндийн салбарын зардлыг бусад онуудтай харьцуулахад 2001 онд 1.1, 2002 онд 1.2, 2003 онд 1.3, 2004 онд 1.7 пунктээр нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбарын зардал жилд дунджаар 10-20% ийн өсөлттэй байна. (Хүснэгт 1)

Санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор нэг хүнд оногдох эрүүл мэндийн зардал 2004 онд 30,6 мянган төгрөг болж 2000 оноос 1,6, 2002 оноос 1,3 дахин өссөн байна.


Зураг 7.1.1. ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардал (хувиар)



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, 2006 он

Дээрх зургаас харахад ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардал 2001 онд хамгийн их хувь 4,9 болж, 2001-2003 онуудад жилд 0,3 хувиар буурч 2003 он гэхэд 4,3 хувьд хүрсэн бөгөөд 2004 онд өмнөх жилээс 0,1 пунктээр өссөн байна. Эндээс ДНБ-ний өсөлттэй эрүүл мэндийн салбарын зардал уялдахгүй байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл 2001-2003 ондуудад ДНБ-ний өсөлт дунджаар 12,5 хувь байхад, эрүүл мэндийн зардлын өсөлт 9,9 хувьтай байна.

Зураг 7.1.2. Эрүүл мэндийн зардлын эх үүсвэр (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, 2006 он


<sup>1</sup>2005 оны Санхүүжилтийн мэдээ гараагүй байсан.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас ихэнх хувь нь бүрдүүлдэг бөгөөд харин бусад орлого болох төлбөрт үйлчилгээний орлого, туслах үйл ажиллагааны орлого бага байна. 2004 онд эрүүл мэндийн салбарын эх үүсвэрийг улсын төсвөөс 70.9 хувь, эрүүл мэндийн даатгалын сангаас 24.1 хувь, төлбөртэй үйлчилгээ буюу бусад үйл ажиллагаанаас 5.0 хувийг бүрдүүлсэн байна.

## 7.2 Эрүүл мэндийн зардал эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалаар

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг шатлал бүрээр авч үзэхэд жил бүрээр нэмэгдсэн байна. 2000 оныг 2004 онтой харьцуулахад анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт 2.0, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээнд зарцуулсан санхүүжилт 1.9, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвүүдийн хувьд 1.5, дахин нэмэгджээ. (Хүснэгт 2)

Зураг 7.2.1. Эрүүл мэндийн зардал эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалаар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, 2006 он

Тусламж үйлчилгээний шатлалаар 2004 оны зардлын бүтцийг авч үзэхэд хоёрдогч шатлал буюу аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 25.5 тэрбум төгрөг буюу 32.9 хувь, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг төвүүдэд 16.7 тэрбум төгрөг буюу 21.6 хувь, анхан шатны тусламж үйлчилгээнд 16.6 тэрбум төгрөг буюу 21.4 хувь, төвлөрсөн арга хэмжээний санхүүжилт 2.2 тэрбум төгрөг буюу 2.8 хувь, бусад байгууллагуудад 16.5 тэрбум буюу 21.3 хувийг тус тус зарцуулсан байна.

“Эрүүл мэндийн суурь тусламжийг хүн амд жигд хүргэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нөөцийг тэгш хуваарилах чадавхийг бүрдүүлэх” ЭМЯ-ны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд хүн амд анхдагч лавлагаа тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх үүргийг хүлээдэг өрх, сумын төвшинд санхүүжилтийг түлхүү олгох бодлого баримталж, 2000 онд 8.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудад олгож байсан бол 2004 оны гүйцэтгэлээр 16.6 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлсэн нь нийт зардалд 21.4 хувийг эзэлж байна.

Төвлөрсөн арга хэмжээний зардалд эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээ болон спортын төвлөрсөн арга хэмжээний зардал ордог бөгөөд 2004 оны байдлаар эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээний зардалд 0,8 тэрбум, спортын төвлөрсөн арга хэмжээний зардалд 1,4 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.




Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг тусламж үйлчилгээний төрлөөр авч үзэхэд 2004 онд нийт даатгалын сангийн зарцуулалтын ихэнх хэсэг 16,79 тэрбум төгрөг буюу 80 хувь нь хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд зарцуулагджээ. Амбулаторын тусламж үйлчилгээнд 2004 онд 1,1 тэрбум төгрөг зарцуулсан нь нийт санхүүжилтийн 5,3%-ийг эзэлж байна. (Хүснэгт 4)

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөн, хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээнээс гадна өрхийн эмнэлэг болон амбулаторын тусламж үйлчилгээг хамруулсан нь эмнэлэгт хэвтэлтийг нэмэгдүүлэх сонирхлыг багасгаж, эрүүл мэндийн үр ашгийг дэмжихэд ихээхэн ач холбогдолтой болно гэж үзсэн. (ЭМЯ, Эрүүл мэндийн салбар 2003)

Иймээс 2003 оноос өрхийн эмнэлгийг даатгалын сангаас санхүүжүүлэх болсонтой холбоотойгоор 230 өрхийн эмнэлэгт 2003 онд 1,6 тэрбум, 2004 онд 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь нийт зардлын 9 хувийг эзэлж байна. Мөн 2005 онд амбулаторийн үзлэгт олгох тарифийг<sup>1</sup> 2 дахин нэмэгдүүлж даатгалын сангаас санхүүжүүлж байна.

Хэдийгээр даатгалын хамрах хүрээг өргөтгөн, санхүүжилтийн хэмжээг удаа дараа нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа ч даатгалын сан нь жил бүр эерэг үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнийг үр ашигтай зарцуулах, тусламж үйлчилгээний чанартай уялдуулах шаардлагатай байна.

**Зураг 7.4.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт салбараар (тэрбум төгрөг)**



Зураг 7.4.3 -аас үзэхэд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн 90 гаруй хувийг улсын салбарт зарцуулж байгаа ч хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад зарцуулах санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна. “Улсын болон хувийн хэвшлийн зохистой харьцаа тогтоож, хувийн хэвшлийг бүх талаар дэмжин хөгжүүлнэ” гэсэн ЭМЯ-ны бодлогын хүрээнд магадлан итгэмжлэгдсэн ортой хувийн эмнэлгүүдэд даатгалын сангаас санхүүжилт олгож байна. Энэ ч утгаараа 2004 онд хувийн хэвшилд 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь 2000 оноос 4 дахин нэмэгдсэн байна.

<sup>1</sup> ЭМС, СС, НХХС-ын 2005.05.05-ны өдрийн 103/125/53 тоот тушаал

**Хүснэгт 7.1 Эрүүл мэндийн санхүүжилтийн үндсэн үзүүлэлт (сая.төг)**

Үзүүлэлт	2000	2001	2002	2003	2004
ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардал (хувиар)	4.6	4.9	4.6	4.3	4.4
Эрүүл мэндийн нийт зардал (сая.төг)	46,860.6	54,281.1	57,662.2	62,067.2	77,571.3
Нэг хүнд ноогдох эрүүл мэндийн зардал (төг)	19,693.3	22,223.6	23,295.0	24,787.0	30,622.8
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр:</b>					
Улсын нэгдсэн төсөв	34,578.9	35,891.1	36,892.8	42,811.3	55,284.1
Эрүүл мэндийн даатгалын сан	9,553.3	14,970.3	18,173.0	15,467.0	18,793.4
Төлбөрт үйлчилгээний болон бусад орлого	2,728.4	3,419.7	2,596.4	3,812.0	3,869.2

**Хүснэгт 7.2 Эрүүл мэндийн санхүүжилт шатлал бүрээр (сая.төг)**

Нийт эрүүл мэндийн зардал шатлал тус бүрээр	2000	2001	2002	2003	2004
Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвүүд	10,920.0	12,519.1	13,402.4	13,835.7	16,739.3
Хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээ	13,498.0	16,890.8	18,045.4	20,755.4	25,525.1
Анхан шатны тусламж үйлчилгээ	8,222.2	9,774.2	12,198.8	13,198.4	16,599.7
Төвлөрсөн арга хэмжээний санхүүжилт	436.1	748.9	823.9	1,535.7	2,196.2
Бусад	13,784.3	14,348.1	13,191.7	12,742.0	16,511.0
<b>Бүгд</b>	<b>46,860.6</b>	<b>54,281.1</b>	<b>57,662.2</b>	<b>62,067.2</b>	<b>77,571.3</b>

**Хүснэгт 7.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн үндсэн үзүүлэлт (сая.төг)**

Үзүүлэлт	2000	2001	2002	2003	2004
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	18,111.2	19,802.6	22,188.3	24,312.5	28,124.6
ЭМД- сангийн зарцуулалт	12,024.1	13,057.6	15,320.1	19,264.9	20,901.4
Нийт хүн ам	2,379,516	2,442,500	2,475,300	2,504,023	2,533,120
ЭМД-ын хамралт (хүн ам)*	2,083,313	1,982,471	1,922,373	2,079,036	2,175,810
Даатгалын хамралтын улсын дундаж (хувиар)	87.6	81.2	77.7	83.0	85.9

\*Нийт хүн амын тоог УСГазрын бодит хүн амын тоогоор авсан тул даатгалын хамралтанд ЭМДГ азын тоотой зөрсөн.

**Хүснэгт 7.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт (сая.төг)**

ЭМД-ын сангийн зарцуулалт	2000	2001	2002	2003	2004
<b>Тусламж үйлчилгээний төрлөөр</b>					
Амбулаторийн тусламж үйлчилгээ	191.7	416.1	607.4	1097.5	1115.2
Стационарийн тусламж үйлчилгээ	11352.7	12010.7	13997.6	15227.5	16792.6
Өрхийн эмнэлэг				1608.8	1828.7
Хөнгөлөлттэй олгох эмийн үнэ	250.6	378.7	424.5	381.8	526.9
Рашаан сувилал	229.1	252.2	290.6	342.8	389.1
Бусад				606.5	248.9
<b>Салбараар</b>					
